



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/132/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СХЗТ	Стандартчилал, хэмжил зүйн төв
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, төлбөр хураамж
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.23 № 1-6/80
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,512,285.36	418,347,615.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,900,000.00	163,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,900,000.00	163,000.00
3121	Төгрөг	2,900,000.00	163,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	2,900,000.00	163,000.00
33	АВЛАГА	0.00	12,460,000.00
335	Бусад авлага	0.00	12,460,000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	12,460,000.00
34	УРЬДЧИЛГАА	200,000.00	65,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	200,000.00	65,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	200,000.00	65,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	149,412,285.36	405,659,615.20
351	Түүхий эд материал	40,650,144.19	77,942,047.23
35110	Тусгай зориулалттай материал	15,299,060.79	14,638,441.29
35130	Эм боох материал	25,351,083.40	63,303,605.94
35300	Бэлэн бүтээгдэхүүн	48,295,249.72	48,127,249.93
354	Хангамжийн материал	60,466,891.45	279,590,318.04
35410	Бичиг хэргийн материал	9,895,616.85	23,087,810.82
35420	Аж ахуйн материал	33,198,110.58	220,770,804.20
35430	Сэлбэг хэрэгсэл	5,575,844.50	12,645,844.50
35440	Түлш, шатах тослох материал	4,078,000.00	7,977,800.00
35470	Бусад хангамжийн материал	7,719,319.52	15,108,058.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	312,732,309.57	356,782,140.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	312,732,309.57	356,782,140.14
392	Биет хөрөнгө	312,293,752.96	356,440,415.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,827,392.00	17,827,392.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-794,003.47	-1,539,235.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171,938,940.00	191,243,940.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,442,442.79	-133,450,591.36
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	290,161,155.22	406,182,635.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-241,139,124.90	-272,889,435.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,362,699.66	45,377,332.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,617,940.20	-26,132,255.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,309,797,413.67	1,311,278,693.67
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,127,800,336.23	-1,181,458,059.39
393	Биет бус хөрөнгө	438,556.61	341,724.34
39301	Програм хангамж	1,158,630.00	1,158,630.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-720,073.39	-816,905.66
39303	Бусад биет бус хөрөнгө	53,899,100.00	53,899,100.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-53,899,100.00	-53,899,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	465,244,594.93	775,129,755.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,000.00	6,320,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,000.00	6,320,000.00
413	Өглөг	100,000.00	6,320,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	6,320,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	465,144,594.93	768,809,755.34
51	Засгийн газрын хувь оролцоо	465,144,594.93	768,809,755.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	826,431,282.30	826,431,282.30
51101	Өмч: - төрийн	826,431,282.30	826,431,282.30
512	Хуримтлагдсан үр дүн	-366,964,048.60	-63,298,888.19
51210	Өмнөх үеийн үр дүн	-114,864,262.50	-366,964,048.60
51220	Тайлант үеийн үр дүн	-252,099,786.10	303,665,160.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,677,361.23	5,677,361.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	465,244,594.93	775,129,755.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,468,307,149.00	2,287,976,083.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,705,749.00	302,030,383.30
120	Нийтлэг татварын бус орлого	67,705,749.00	302,030,383.30
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	67,705,749.00	302,030,383.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,900,000.00	37,402,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,805,749.00	264,628,183.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,400,601,400.00	1,985,945,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	95,176,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	95,176,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,398,601,400.00	1,890,769,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,398,601,400.00	1,890,769,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,487,332,714.59	1,984,282,499.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,487,332,714.59	1,984,282,499.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,690,479.52	1,795,729,760.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	875,439,303.00	1,147,615,719.96
210101	Үндсэн цалин	700,066,303.00	823,730,811.11
210102	Нэмэгдэл	144,889,000.00	288,400,623.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,484,000.00	35,484,285.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,611,037.41	146,591,101.93
210201	Тэтгэврийн даатгал	75,241,619.00	100,006,304.15
210202	Тэтгэмжийн даатгал	8,851,955.41	11,765,661.72
210203	ҮОМШ өвчний даатгал	7,071,324.00	9,335,250.05
210204	Ажилгүйдлын даатгал	1,767,829.00	2,316,718.17
210205	Эрүүл мэндийн даатгал	17,678,310.00	23,167,167.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,785,724.00	77,013,678.00
210301	Гэрэл цахилгаан	202,044.00	1,578,841.00
210302	Түлш, халаалт	1,254,400.00	2,489,653.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	85,184.00
210304	Байрны түрээс	21,329,280.00	72,860,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,224,414.03	61,450,813.56
210401	Бичиг хэрэг	12,790,085.41	10,105,390.38
210402	Тээвэр, шатахуун	20,872,844.40	30,587,448.30
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	14,230,463.52	13,753,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,460,000.00	700,000.00
210408	Бараа материал акталсны зардал	22,871,020.70	6,304,014.88
2105	Нормативт зардал	72,062,238.82	104,224,600.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,814,638.82	92,510,035.55
210502	Хоол, Хүнс	2,247,600.00	11,433,673.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	280,891.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,111,273.62	113,545,457.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	86,700.00	103,512,423.96
210604	Урсгал засвар	12,024,573.62	10,033,034.01
2107	Томилолт, зочны зардал	8,255,350.00	7,217,600.00
210702	Дотоод албан томилолт	8,255,350.00	7,217,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,767,693.99	34,736,742.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	9,024,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,411,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	998,400.00	999,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	384,175.00	147,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,178.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,045,600.00	1,822,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,274,340.99	21,232,342.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,433,444.65	103,334,046.28
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	2,308,100.00	270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	63,125,344.65	103,064,046.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,642,235.07	188,552,739.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,788,400.00	92,015,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	24,018,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,788,400.00	67,996,800.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	209,853,835.07	93,637,339.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	209,853,835.07	93,637,339.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	2,900,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19,025,565.59	303,693,583.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	233,079,915.82	28,423.15
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	233,079,915.82	28,423.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-233,079,915.82	-28,423.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-252,105,481.41	303,665,160.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,295,778,320.00	3,180,672,816.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	895,176,920.00	1,194,727,116.76
120	Нийтлэг татварын бус орлого	895,176,920.00	1,194,727,116.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	895,176,920.00	1,194,727,116.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	895,176,920.00	1,194,727,116.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,400,601,400.00	1,985,945,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,398,601,400.00	1,890,769,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,398,601,400.00	1,890,769,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	95,176,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	95,176,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,290,565,520.00	3,177,174,616.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,290,565,520.00	3,177,174,616.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,183,646,364.93	1,831,296,960.89
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	875,266,003.00	1,147,580,719.96
210101	Үндсэн цалин	664,818,703.00	823,695,811.11
210102	Нэмэгдэл	173,866,800.00	269,715,703.65
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	36,580,500.00	35,484,285.20
210104	Урамшуулал	0.00	18,684,920.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,611,037.41	146,591,101.93
210201	Тэтгэврийн даатгал	75,241,619.00	100,006,304.15
210202	Тэтгэмжийн даатгал	8,851,955.41	11,765,661.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,071,324.00	9,335,250.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,767,829.00	2,316,718.17
210205	Эрүүл мэндийн даатгал	17,678,310.00	23,167,167.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,785,724.00	77,013,678.00
210301	Гэрэл, цахилгаан	202,044.00	1,578,841.00
210302	Түлш, халаалт	1,254,400.00	2,489,653.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	85,184.00
210304	Байрны түрээс	21,329,280.00	72,860,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,271,395.52	69,750,431.00
210401	Бичиг хэрэг	10,738,871.00	20,031,900.00
210402	Тээвэр, шатахуун	19,257,900.00	34,487,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,230,463.52	13,162,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,460,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	584,161.00	1,367,771.00
2105	Нормативт зардал	73,324,510.00	132,902,585.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,076,910.00	125,120,300.00
210502	Хоол, хүнс	2,247,600.00	7,249,396.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	532,889.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,361,030.00	218,236,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,615,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	207,408,000.00
210604	Урсгал засвар	13,361,030.00	9,212,800.00
2107	Томилолт, зочны зардал	8,255,350.00	7,217,600.00
210702	Дотоод албан томилолт	8,255,350.00	7,217,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,463,215.00	31,734,345.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	10,334,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	1,411,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	998,400.00	999,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	384,175.00	147,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,178.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,045,600.00	3,047,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,697,862.00	15,694,945.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,308,100.00	270,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,308,100.00	270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,106,919,155.07	1,345,877,655.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,788,400.00	85,695,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	24,018,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,788,400.00	61,676,800.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	925,039,755.07	1,102,070,755.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	925,039,755.07	1,102,070,755.87
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,895,000.00	65,096,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,895,000.00	65,096,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,196,000.00	93,015,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	122,196,000.00	93,015,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,212,800.00	3,498,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,312,800.00	6,235,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,312,800.00	6,235,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,312,800.00	6,235,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,312,800.00	6,235,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,312,800.00	-6,235,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,212,800.00	3,498,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,900,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,900,000.00	163,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(114,864,262.50)	-	717,244,381.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(114,864,262.50)	-	717,244,381.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(252,099,786.10)	-	(252,099,786.10)
C08	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(366,964,048.60)	-	465,144,594.93
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(366,964,048.60)	-	465,144,594.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(366,964,048.60)	-	465,144,594.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	303,665,160.41	-	303,665,160.41
D09	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	826,431,282.30	5,677,361.23	(63,298,888.19)	-	768,809,755.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,900,000.00		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,890,769,700.00	1,834,467,664.89	56,302,035.11	97%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,890,769,700.00	1,834,467,664.89	56,302,035.11	97%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,861,951,100.00	1,805,652,264.89	56,298,835.11	97%
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,192,521,400.00	1,147,580,719.96	44,940,680.04	96%
210101	Үндсэн цалин	902,768,400.00	823,695,811.11	79,072,588.89	91%
210102	Нэмэгдэл	225,090,200.00	269,715,703.65	-44,625,503.65	120%
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	37,064,500.00	35,484,285.20	1,580,214.80	96%
210104	Урамшуулал	27,598,300.00	18,684,920.00	8,913,380.00	68%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,245,100.00	146,591,101.93	4,653,998.07	97%
210201	Тэтгэврийн даатгал	102,368,200.00	100,006,304.15	2,361,895.85	98%
210202	Тэтгэмжийн даатгал	12,219,200.00	11,765,661.72	453,538.28	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,775,400.00	9,335,250.05	440,149.95	95%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,443,800.00	2,316,718.17	127,081.83	95%
210205	Эрүүл мэндийн даатгал	24,438,500.00	23,167,167.84	1,271,332.16	95%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,229,900.00	77,013,678.00	1,216,222.00	98%
210301	Гэрэл, цахилгаан	2,462,700.00	1,578,841.00	883,859.00	64%
210302	Түлш, халаалт	2,916,900.00	2,489,653.00	427,247.00	85%
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	85,184.00	114,816.00	43%
210304	Байрны түрээс	72,650,300.00	72,860,000.00	-209,700.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	70,484,400.00	70,475,331.00	9,069.00	100%
210401	Бичиг хэрэг	20,031,900.00	20,031,900.00	0.00	100%
210402	Тээвэр, шатахуун	34,487,800.00	34,487,800.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,167,700.00	13,162,960.00	4,740.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,097,000.00	2,092,671.00	4,329.00	100%
2105	Нормативт зардал	126,703,700.00	126,703,189.00	511.00	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,920,700.00	123,920,300.00	400.00	100%
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	532,889.00	111.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	206,816,800.00	206,525,800.00	291,000.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,540,000.00	5,540,000.00	0.00	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	192,064,000.00	191,773,000.00	291,000.00	100%
210604	Урсгал засвар	9,212,800.00	9,212,800.00	0.00	100%
2107	Томилголт, зочны зардал	12,035,700.00	7,217,600.00	4,818,100.00	60%
210702	Дотоод албан томилолт	12,035,700.00	7,217,600.00	4,818,100.00	60%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,644,100.00	23,274,845.00	369,255.00	98%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,239,700.00	1,875,200.00	364,500.00	84%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	1,411,200.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	999,700.00	300.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,000.00	147,000.00	0.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	99,000.00	1,000.00	99%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,047,800.00	3,047,800.00	0.00	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,698,400.00	15,694,945.00	3,455.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,000.00	270,000.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	270,000.00	270,000.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,818,600.00	28,815,400.00	3,200.00	100%

2132	Бусад урсгал шилжүүлэг	28,818,600.00	28,815,400.00	3,200.00	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,018,600.00	24,018,600.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	4,796,800.00	3,200.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,890,769,700.00	1,828,051,560.89	62,718,139.11	97%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,890,769,700.00	1,828,051,560.89	62,718,139.11	97%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	163,000.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	95,176,000.00	-95,176,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	88,759,896.00	-88,759,896.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	31,879,896.00	-31,879,896.00
2105	Нормативт зардал	0.00	6,199,396.00	-6,199,396.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	1,200,000.00	-1,200,000.00
210502	Хоол, хүнс	0.00	4,999,396.00	-4,999,396.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,221,000.00	-17,221,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,586,000.00	-1,586,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	15,635,000.00	-15,635,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	8,459,500.00	-8,459,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	8,459,500.00	-8,459,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	56,880,000.00	-56,880,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	56,880,000.00	-56,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	56,880,000.00	-56,880,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	6,416,104.00	-6,416,104.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	6,416,104.00	-6,416,104.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	95,176,000.00	-95,176,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	95,176,000.00	-95,176,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	95,176,000.00	-95,176,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 01/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, олон улсын хүний хорио болон мал амьтны Олон улсад шуурхай, тогтмол мэдээлэх халдварт өвчин, ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал улсын хилээр нэвтрэх, бусад урс оронд дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, импорт, экспортын бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 806,469.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,064.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд нийт зардлын 1,990,630.9 мянган төгрөгийн 1 хувиар тооцож 19,906.3 мянган төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатны хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,049.8 мянган төгрөгөөр буюу 67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,900.0	163.0	(2,737.0)
Авлага	-	12,460.0	12,460.0
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал	149,412.3	405,659.6	256,247.3
Үндсэн хөрөнгө	312,732.3	356,782.1	44,049.8
Нийт хөрөнгө	465,244.6	775,129.8	309,885.2
Өр төлбөр	100.0	6,320.0	6,220.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	826,431.30	826,431.30	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	465,244.6	775,129.8	309,885.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 163.0 мянган төгрөг болж 2,737.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь арилжааны банканд жилийн эцсийн данс хаасны дараа гүйлгээ орсноор мөнгөн хөрөнгийн үлдэгдэл үүссэн байна. Энэ нь шинжилгээ, гэрчилгээний төлбөрийн орлогууд байна.

Авлага дансны үлдэгдэл 12,460.0 мянган төгрөг болж 12,460.0 төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2020 оны жилийн эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас улсын төсөвт буцаан төвлөрүүлэг, СХЗГ-т шилжүүлэх төлбөрийг СХЗТ-д шилжүүлснээр 800.0 мянган төгрөгийн, Их-Уул трейд ХХК-д лабораторийн шинжээч нарт 540.0 мянган төгрөгийн үнэ бүхий нормын хувцас захиалсан боловч цар тахалтай холбоотойгоор үйлдвэр ажиллагаагүйгээс, Монос трейд ХХК-д халуун хэмжигч захиалсан боловч 2020 оны жилийн эцэст ирээгүйгээс 4,800.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 405,659.6 мянган төгрөг болж 256,247.3 мянган төгрөгөөр өссөн нь Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны батлагдсан төсөвт 2020 оны 12 сард нэмэлт өөрчлөлт орж эд хогшил, урсгал засварын

зардлыг анх батлагдсан төсвөөс 189,285.0 мянган төгрөгөөр, норматив зардлыг 44,999.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Төсөвт нэмэлт өөрчлөлт орсноор МХЕГ-аас ариутгал, халдваргүйтгэлтэй холбоотойгоор зарим бараа материалын нөөц үүсгэх чиглэл өгсний дагуу худалдан авалт хийсэн нь бараа материалын үлдэгдлийг өсгөсөн байна. Материаллаг өөрчлөлт орсон зардал эм боох материал, аж ахуйн материал байна. Аж ахуйн материалын үлдэгдэлд хамгаалах өмсгөл нийт үлдэгдлийн дийлэнх хувийг эзэлж байна. Үнэ төлбөргүйгээр МХЕГ, иргэн, ААНБ-аас 123,721.1 мянган төгрөгийн бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 356,782.1 мянган төгрөг болж 44,049.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд 6,235.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, МХЕГ-аас 119,952.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө авсан, Замын-Үүд сумын ЗДТГ-аас 19,305.0 мянган төгрөгийн автомашин өгсөн, ААНБ-ын хандив тусламжаар 1,650.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 4,139.9 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу акталсан байна. Тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,320.0 мянган төгрөг болж 6,220,0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2020 оны 12 сард цар тахлаас урьдчилан сэргийлэхэд эрсдэлтэй бүсэд ажиллаж байгаа ажиллагсад 6,320.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Урамшууллын ХХОАТ болох 6,320.0 төгрөгийг шилжүүлэх гүйлгээ хийсэн боловч 2020 оны 12 сарын дансны хуулгаар гүйлгээ гараагүй учир өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 819,668.9 мянган төгрөгөөр буюу 44.2 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс олгосон санхүүжилт, үнэ төлбөргүй орлого, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 1,990,602.5 мянган төгрөгөөр буюу 33.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал өсөж, хангамж бараа материалын зардал буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,707,680.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,707,680.9 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2020 оны 12 сард 183,088.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,890,769.7 мянган төгрөг болгон нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,890,769.7 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор төлөвлөжээ

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,890,769.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 56,302.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,834,467.7 мянган төгрөг буюу 97 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 12,976.0 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 80,200.0 мянган төгрөгийн, Замын-Үүд сумын ЗДТГ-аас 1,000.0 мянган төгрөгийн, ОБХ-ээс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулж, 6,416.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 112 мэдээллээс, 96 мэдээлэл хугацаанд нь оруулсан, 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,358.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлагыг хүргүүлснийг хэрэгжүүлсэн тухай албан бичгийг ирүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	2	2,358.5	2	2,358.5			
Зөвлөмж							
Нийт дүн	2	2,358.5	2	2,358.5			

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 687,977.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 669,925.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 18,051.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага тогтоож, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй 663,779.6 мянган төгрөгийн 83 гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасныг залруулав.
- Байгууллагын 2020 оны жилийн эцсийн НББ-ийн ерөнхий журналаас орлогын гүйлгээг авч үзэхэд төсөвт байгууллагын өөрийн орлого буюу лабораторийн шинжилгээ, ариутгал, гэрчилгээ, ломбо лац, торгуулийн шийтгэлийн төлбөрийн төвлөрүүлсэн орлогын дүн 5,800.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг аудитын явцад залруулав.
- Нэмэлт санхүүжилтийн данснаас буцаан төвлөрүүлсэн 6,146.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүйг аудитын явцад залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 18,051.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 18,051.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд МХЕГ-ын даргын 2020 оны 4 сарын 23-ны өдрийн А/57 дугаар тушаалаар шинэ коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр онцгой үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад урамшуулал олгох тухай тушаал гарснаар нийт 8,459.5 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Урамшууллын зардлыг МХЕГ-аас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосныг ХМХА-аас төрийн санд нэмэгдэл цалингийн зардалд зарцуулах эрх хүссэн албан бичгийг хүргүүлсэн боловч БГАҮТХ-ын зардлаас зарцуулах эрхийг нээж өгснөөр эдийн засгийн ангилал зөрчиж цалин урамшуулал олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын БГАҮТХ /210801/-д “Гуравдагч этгээдээр аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоолгох үйлчилгээг хийлгэхэд гарах зардал, ...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоох.

2. Тайлант онд цар тахалтай холбоотойгоор 3 иргэн, хувийн 13 ААНБ болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа консулаас нийт 9,592.0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийн хандив тусламж авсан бана. Хандив тусламжийг авахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, НАНБХАСЗАСКУСТХ-ийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно”, 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоох.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой:

- 1.1. Илрүүлэлт Биет бус хөрөнгийн дансанд /39303/ 53,899.1 мянган төгрөгийн биет бус хөрөнгө буюу зураг төсөв бүртгэлтэй байна. Энэ зураг нь гаалийн цогцолборын хажууд шинээр албан байр барихаар хийлгэсэн ба одоо шинээр цогцолбор баригдсан ба энэ зургаар барилга барих боломжгүй болсон байна. Одоо лабораторийн барилга нь Азийн хөгжлийн банкны зураг төсөв, хөрөнгө оруулалтаар барилга баригдаад эхэлсэн байна. Энэ зураг нь ашиглалтгүй биет бус хөрөнгө байна.
- 1.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтгүй хөрөнгө хөрөнгийн дүнг өсгөх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 7.1-д “...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж, шийдвэрлүүлнэ” гэж заасныг дагуу ашиглах хугацаа дууссан хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг тогтоох, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах асуудлыг холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлж, ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021/02/18	Аудитын нэр: Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/132/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй 663,779.6 мянган төгрөгийн 83 гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.	663,779.6	Аудитын явцад залруулав	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг
2	Байгууллагын 2020 оны жилийн эцсийн НББ-ийн ерөнхий журналаас орлогын гүйлгээг авч үзэхэд төсөвт байгууллагын өөрийн орлого буюу лабораторийн шинжилгээ, ариутгал, гэрчилгээ, ломбо лац, торгуулийн шийтгэлийн төлбөрийн төвлөрүүлсэн орлогын дүн 5,800.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	5,800.0	Аудитын явцад залруулав	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг
3	Нэмэлт санхүүжилтийн данснаас буцаан төвлөрүүлсэн 6,146.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.	6,146.1	Аудитын явцад залруулав	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг
4	Тайлант онд МХЕГ-ын даргын 2020 оны 4 сарын 23-ны өдрийн А/57 дугаар тушаалаар шинэ короновирус халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр онцгой үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад урамшуулал олгох тухай тушаал гарснаар нийт 8,459.5 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Урамшууллын зардлыг МХЕГ-аас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосныг ХМХА-аас төрийн санд нэмэгдэл цалингийн зардалд зарцуулах эрх хүссэн албан бичгийг хүргүүлсэн боловч БГАҮТХ-ын зардлаас зарцуулах эрхийг нээж өгснөөр эдийн засгийн ангилал зөрчиж цалин урамшуулал олгосон байна.	8,459.5	Албан шаардлага тогтоох	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг
5	Тайлант онд цар тахалтай холбоотойгоор 3 иргэн, 13хувийн ААНБ болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа консулаас нийт 9,592.0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийн хандив тусламж авсан бана. Хандив тусламжийг авахдаа холбогдох	9,592.0	Албан шаардлага тогтоох	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг

	дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.				
6	Биет бус хөрөнгийн дансанд /39303/ 53,899.1 мянган төгрөгийн биет бус хөрөнгө буюу зураг төсөв бүртгэлтэй байна. Энэ зураг нь гаалийн цогцолборын хажууд шинээр албан байр барихаар хийлгэсэн ба одоо шинээр цогцолбор баригдсан ба энэ зургаар барилга барих боломжгүй болсон байна. Одоо лабораторийн барилга нь Азийн хөгжлийн банкны зураг төсөв, хөрөнгө оруулалтаар барилга баригдаад эхэлсэн байна. Энэ зураг нь ашиглалтгүй биет бус хөрөнгө байна.		Зөвлөмж хүргүүлэх	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	С.Цогбадрах Ц.Оюунчимэг
	ДҮН	687,977.2			